МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 31 өдөр Дугаар А/317 Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд Хүүхдийн эрхийг хамгаалах Олон улсын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд хүүхдийг болзошгүй осол, аюулаас урьдчилан сэргийлэх, тэдгээрээс үүсч болох хор хохирлыг багасгах хяналт тавих чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Б.Батбилгүүн
(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд: А.Үүрийнцолмон
Эрүүл мэндийн газрын Хүнсний эрүүл ахуйн хяналтын улсын Ахлах байцаагч

Д.Аюушжав
(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсын байцаагч)

Ч.Цэрэнсүрэн
(Аймгийн Засаг даргын тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсын байцаагч)

Ч.Өлзийорших
Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хүнсний чанарын хяналтын улсын байцаагч

Д.Мягмарсүрэн
(Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын Барилын техникийн хяналтын улсын байцаагч)

П.Даваа-Очир
(Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Өргөх механизмын хяналтын улсын байцаагч)

671?010393

Б.Удвал
(Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын
Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч)

Нарийн бичгийн дарга: Х.Сэрчинмаа
(Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын
Хүүхдийн эрх, хамгаалал хариуцсан мэргэжилтэн)

2. Хяналт, шалгалтын ажлыг 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн 06 дугаар сарын 01-ний өдрийг дуустал хугацаанд зохион байгуулж, холбогдох албан хаагчдыг нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Батбилгүүн)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т даалгасугай.

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ,
ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ М.ХУЯГБААТАР